



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/43

Улаанбаатар хот

Улсын комисс томилон
ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.13, Эрчим хүчний сайдын 2019 оны 125 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж барих ажлын журам”-ын 3.2, “Дэлхийн банкны Эрчим хүчний төсөл-2”-ын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 23 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд хэрэгжүүлсэн “Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын 6-0.4 кВ-ын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх, сайжруулах” барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан уг барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах Улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

Комиссын дарга:

Ш.Ганзориг

-Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Төгөлдөр

-Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахилгааны хэлтсийн мэргэжилтэн

Р.Ширчинням

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнгөнцэцэг

-Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Архивын тасгийн дарга

Т.Жанчив

-Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын Эрчим хүчний улсын байцаагч

Б.Гантөгс

-Хэнтий аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн

Р.Мөнхдорж

-Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын Гал унтраах 49 дүгээр ангийн Гал түймрийн улсын байцаагч

• 170600000093

А.Лхамсүрэн

Ё.Болдбаатар

Э.Батбаяр

Д.Ариунбаатар

-“Багануур Зүүн Өмнөд Бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төслийн ахлагч
-“Багануур Зүүн Өмнөд Бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Говьсүмбэр цахилгаан түгээх сүлжээ салбарын Түгээх үйл ажиллагаа хариуцсан менежер бөгөөд ерөнхий инженер
-“Баясалтөгс” ХХК-ийн Ерөнхий инженер бөгөөд зургийн зохиогч /зөвшилцсөнөөр/
-“Мон – Энержи корпораци” ХХК -ийн Ерөнхий инженер бөгөөд барилга угсралтын ажлын гүйцэтгэгч /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

Х.Оюунбилэг

-Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”-ын төсөл хэрэгжүүлэх нэгжийн инженер

2.Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахыг Улсын комисс /Ш.Ганзориг/-т даалгасугай.

САЙД



Б.ЧОЙЖИЛСҮРЭН